

Авто тээврийн байгууллагын үүсэл

1925 онд анх 7 машин, 10 гаруйхан ажилчин тайгаар суурь тавигдсан манай улсын авто тээврийн байгууллага 1970 оны байдлаар 10000 гаруй ажилтантай болжээ.

1930-11-14-энд сайд нарын Зөвлөлийн 38 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Улаанбаатар хотод авто бааз, уран дархан үйлдвэр, уурын тэрэгний үйлдвэрийн сургуулийн барилгыг барьж дуусгасан гэж тэмдэглэжээ.

1936-9-25-анд Сайд нарын Зөвлөлийн 41 дүгээр хурлын 2 дугаар зүйлээр Улаанбаатар хотын гудамж зээлээр явах, зорчих журмын тухай зааврыг баталж 1936-10-15наас эхлэн дагаж мөрдөхөөр тогтоожээ.

1960 онд сайд нарын Зөвлөлийн 54 дүгээр тогтоолоор хотын захиргааны харьяа олон жижиг бааз, гараашуудыг нэгтгэн худалдаа нийтийн хоолны Триестийн авто бааз, нийгэм хангамжийн үйлчилгээний авто бааз болгон байгуулж, хотын жижиг албан газруудын 56 авто машиныг шилжүүлэн өгч богинын тээврийн баазыг байгуулжээ.

1964 оны улсын төлөвлөгөөний тухай илтгэлд 1965 онд Улаанбаатар хотод 1000 машин, 500 мотор засах заводын ашиглалтад оруулан АН-24 маркийн нисэх онгоц агаарын тээвэрт хэрэглэж эхэлнэ гэжээ.

1966-2-25-нд сайд нарын Зөвлөлийн 60 дугаар тогтоолоор Улаанбаатар хотоос орон нутагт орон нутгаас, Улаанбаатар хотод ачаа тээх ажлыг Улаанбаатар хотын нэгдсэн Авто аж ахуйгаар үйлчлүүлж байх төвлөрсөн тээврийн журмыг 1966-4-1-нээс эхлэн тогтоож, авто тээврээр ачаа тээвэрлэх дүрмийг баталжээ

1970-10-9-нд сайд нарын Зөвлөлийн 308 дугаар тогтоолоор яам, тусгай газар, улс орон олон нийтийн албан газар, байгууллагын мэдэлд байгаа ачааны авто машинуудыг нэгтгэн Авто тээврийн төвлөрсөн үйлчилгээнд оруулж хотын худалдаа, нийтийн үйлчилгээний аж ахуй худалдаа үйлчилгээний хэрэгцээнд үйлчлэх худалдаа, нийтийн үйлчилгээний тээврийн авто бааз, албан байгууллагын аж ахуйн хэрэгцээнд үйлчлэх авто бааз гэж тус тус байгуулан Улаанбаатар хотын тээврийг удирдах газрын харьяанд ажиллуулахаар тогтоожээ.

1970-12-26-нд сайд нарын Зөвлөлийн 401 дүгээр тогтоолоор дизель хөдөлгүүртэй их даацын авто машиныг төвлөрүүлж, хот хоорондын ачаа тээврийн авто баазыг 1971-1-1-нээс эхлэн байгуулахаар тогтоожээ.

1974-9-16-нд Намын Төв, Хороо, сайд нарын Зөвлөлийн 31 дүгээр тогтоолоор хотын албан үйлдвэр, аж ахуй, соёл, нам олон нийтийн байгууллагад ажиллаж байгаа суудлын авто машиныг Нийтийн хэрэгцээний авто тээврийн байгууллагад нэгтгэн төвлөрүүлж, албан ажлын хэрэгцээний уналгыг нийтийн хэрэгцээний авто тээврийн байгууллагаас хангадаг журамд шилжихэд Улаанбаатар хотод 1976-1977 онд журамлаж Авто тээврийн ачаа зорчигчид, тээвэрлэлтийн өсөлт Тээвэрлэсэн ачаа / сая тн/ 1960 онд 3.4, 1974 онд 10.6. Ачаа эргэлт /сая тн, км/ 1960 онд 201,4, 1974 онд 735,2 Зорчигчдын тоо / сая хүн/

1960 онд 17.6 1974 онд 77.7 зорчигчид эргэлт /сая хүн км/ 1960 онд 118.4 сая 1974 онд 313.4 болж өсжээ.

Хотын доторх зорчигчид тээврийн өсөлт Автобусаар зорчигчдын тоо / сая хүн/ 1960 онд 17.3, 1974 онд 77.6

Автобус тээврийн зорчигчид эргэлт /сая хүн км/ 1960 онд 58.5 1974 онд 283,6